



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 11 өдөр

Дугаар A/239

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай


Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэр (Мандал-18-1801а тоот)-т байршилтай Пүрэвдорж овогтой Дэлгэрцэцэг (ЗЮ:83042605)-ийн орон сууцны зориулалттай 300 м.кв (0,03га) газрыг Лхагвасүрэн овогтой Нэргүйбаатар (ЗЮ:83071673)-т зориулалтаар нь шилжүүлж 13 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 18 -ны өдрийн А/334 дугаар захирамжийн иргэн П.Дэлгэрцэцэг-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 000025626 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010588